

Г

Г

## Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Танай ирүүлсэн 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн тодруулгын дагуу хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Эмэгтэй кительний зургаас хараад энгэрийн зерлөг нь баруун тийшээ буюу эрэгтэй зөрлөгөөр дарсан байна. Зөрлөгийг баруун тийш дарж зургийн дагуу эх загварыг хийх эсэх;

### **Хариу- Техникийн тодорхойлолтын зургийн дагуу байна.**

2. Эмэгтэй кителийн Техникийн тодорхойлолт дахь зургаас хараад байгууллагын лого буюу таних тэмдэг нь Зүүн энгэрт хатгасан байна. Гэвч техникийн тодорхойлолт дээрхи уг өгүүлбэрт "таних тэмдэгийг баруун талын цээжний хэсэгт" гэж зургаас зөрүүтэй заасан байна. Иймд таних тэмдэгийг цээжний баруун болон зүүн хэсгийн аль хэсэгт хатгах вэ;

### **Хариу-Техникийн тодорхойлолтын дагуу баруун хэсэгт хатгаж оёсон байна.**

3. Даашины зургаас хараад энгэрийн цээж хэсгээр кителийн нэгэн адил баруун тийш дарсан харагдаж байна. Техникийн тодорхойлолт дээр урд, ард эсвэл хажуу талын аль нэг хэсэгт өмсөхөд зориулсан онгойх цахилгаантай байх талаар огт дурьдаагүй байна. Иймээс үүнийг тодорхой болгож өгнө үү.

**Хариу-Даашиныг техникийн тодорхойлолтын дагуу баруун тийш дарж оёсон байх ба даашиныг өмсөхөд зориулсан онгойх цахилгааныг ар талд далд цахилгаанаар оёно.**

4. Өмнөх тендерт манай компани оролцохдоо даашины далд халаасыг зургийн дагуу хийсэн боловч " далд халаас хийгээгүй" гэж шаардлага хангагүй байсан. Иймээс Та бүхэн халаасыг зургийн дагуу хавчуургатай далд халаасаар хийлгэх эсвэл даашины ташааны оёдол дагуу далд халаас гаргуулахыг хүсэж байна уу?

**Хариу-Техникийн тодорхойлолтод тусгагдсан даашины ташааны оёдлын дагуу далд халаастай байна.**

5. Мөн даашины энгэрийн таних тэмдгийг зургийн дагуу зүүн цээжний хэсэгт хатгах уу, эсвэл баруун хэсэгт хатгах уу?

### **Хариу-Даашины энгэрийн таних тэмдгийг цээжний баруун хэсэгт байрлуулна.**